



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИВЭЭ-ОВОО ХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/59/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261628 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитын гэрээгээр гүйцэтгэсэн: Ниямазон аудит ХХК
Захирал: З.Цээнээ
Утас: 70145906 Цахим хаяг: audit@nmz.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал.....	12
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	13
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	13
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	17
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
8. Аудитын илрүүлэлт	19
8.1 Зөвлөмж.....	19
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20
10. Хавсралт: Албан шаардлага	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нотлох ажил
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИВЭЭ-ОВОО ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

2022.03.15 № 07/624
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь нийт орлогыг 65,449.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 70,395.0 сая төгрөгөөр, алдагдлыг 4,945.1 сая төгрөгөөр тогтоож төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 59,588.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 68,212.0 сая төгрөгийн зардал гарган 8,623.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 424 худалдан авах ажиллагаанд 55,332.0 сая төгрөг төлөвлөснөөс 625 төрлийн бараа ажил үйлчилгээнд 40,085.1 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндсэн чиглэлийн 5 зорилтын хүрээнд 212 арга хэмжээ, ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.9 хувийн гүйцэтгэлтэй, бүх нэгжүүдэд 2040 үүрэг даалгавар өгөгдөж 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦНАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,881,311,227.79	409,413,858.07
1.1.2	Дансны авлага	5,843,208,271.02	5,929,917,612.61
1.1.4	Бусад авлага	188,654,163.75	337,141,659.70
1.1.5	Найдваргүй авлагын хасагдуулга	(3,191,012,968.00)	(3,164,825,113.00)
1.1.6	Бараа материал	16,903,451,136.04	16,829,574,285.68
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,880,137,749.43	2,869,615,048.52
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	28,505,749,580.04	23,210,837,351.59
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	61,594,328,702.51	64,900,040,306.76
1.2.2	Биет бус хөрөнгө	189,628,430.36	189,628,430.36
1.2.3	Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	(2,674,133,497.20)	(2,674,133,497.20)
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	627,169,395.40	627,169,395.40
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	546,516,329.78	299,047,422.19
1.2.9	Хөрс хуулалтын хөрөнгө	34,287,341,156.41	34,287,341,156.41
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	94,570,850,517.26	97,629,093,213.93
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	123,076,600,097.30	120,839,930,565.52
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	24,609,791,331.26	23,945,246,003.38
2.1.1.2	Цалингийн өглөг	971,585,743.00	1,525,918,018.00
2.1.1.3	Татварын өр	10,129,621,951.80	8,514,981,825.53
2.1.1.4	НДШ-ийн өглөг	5,508,113,895.80	5,626,833,297.38
2.1.1.5	Богино хугацаат зээл	3,620,000,000.00	1,800,000,000.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	17,218,516.06	12,383,905.66
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	7,342,806,442.56	8,017,100,204.42
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	52,212,179,790.58	49,455,505,164.48
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	2,839,665,871.35	3,082,485,281.67
2.1.2.2	Засгийн газрын дэмжлэг	59,195,878,218.04	68,424,356,969.24
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	358,564,643.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	12,409,553,694.38	12,244,553,694.38
2.1.2.5	Ажилчдын тэтгэврийн сан	940,762,661.73	719,422,661.73
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	75,744,425,088.50	84,470,818,607.02
2.2	Өр төлбөрийн нийт дүн	127,956,604,879.08	133,926,323,771.50

2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
2.3.2	-хувийн	134,190,000.00	134,190,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(6,221,904,781.78)	(14,428,293,205.97)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(4,880,004,781.78)	(13,086,393,205.97)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	123,076,600,097.30	120,839,930,565.3

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	57,721,868,344.00	59,347,899,558.32
2	Борлуулалтын өртөг	56,015,188,490.39	63,717,687,239.32
3	Нийт ашиг(алдагдал)	1,706,679,853.61	(4,369,787,681.00)
4	Хүүгийн орлого	4,086,235.41	0.00
5	Бусад орлого	135,991,682.38	240,501,231.00
6	Борлуулалт, маркетингийн зардал	661,202,154.00	712,335,896.60
7	Ерөнхий ба удирдлагын зардал	981,173,797.22	1,082,920,723.86
8	Санхүүгийн зардал	807,530,792.58	692,635,632.86
9	Бусад зардал	1,727,675,544.85	1,803,544,887.31
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(6,200,154.11)	(28,734,014.49)
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	32,720,940.38	(173,096,523.04)
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(2,304,303,730.98)	(8,622,554,128.16)
13	Орлогын татварын зардал	408,624.85	1,086,488.14
14	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,304,712,355.83)	(8,623,640,616.30)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,304,712,355.83)	(8,623,640,616.30)
16	Орлогын нийт дүн	(2,304,712,355.83)	(8,623,640,616.30)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан*2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон**/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(3,917,192,425.94)	(2,575,292,425.94)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(2,304,712,355.83)	(2,304,712,355.83)
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(6,221,904,781.77)	(4,880,004,781.76)
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	417,252,192.10	417,252,192.10
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(5,804,652,589.67)	(4,462,752,589.67)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(8,623,640,616.30)	(8,623,640,616.30)
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(14,428,293,205.97)	(13,086,393,205.97)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	60,185,873,570.15	62,823,819,193.62
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	59,967,432,891.29	62,242,125,916.76
	Бусад мөнгөн орлого	218,440,678.86	581,693,276.86
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,035,459,961.37	60,908,830,254.07
	Ажиллагчдад төлсөн	8,637,295,100.00	8,982,279,693.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,032,308,166.75	3,363,500,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	18,298,639,840.79	17,374,809,082.27
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	11,485,531,251.86	15,744,781,149.18
	Хүүгийн төлбөрт төлсөн	398,535,091.71	314,149,742.48
	Татварын байгууллагад төлсөн	1,483,229,610.48	5,933,646,973.21
	Бусад мөнгөн зарлага	5,699,920,899.79	9,195,663,613.93
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,150,413,608.78	1,914,988,939.55
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,832,020,135.57	2,053,496,247.85
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,959,584,798.62	1,786,750,977.11
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	97,038,000.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	4,775,397,336.95	266,745,270.74
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,832,020,135.57)	(2,053,496,247.85)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,390,000,000.00	5,000,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,390,000,000.00	5,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,037,929,376.60	7,333,390,061.42
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	6,324,240,000.00	7,041,340,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	458,095,827.60	165,000,000.00
	Буцалтгүй тусламж	255,593,549.00	127,050,061.42
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	352,070,623.40	(2,333,390,061.42)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,670,464,096.61	(2,471,897,369.72)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,210,847,131.18	2,881,311,227.79
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,881,311,227.79	409,413,858.07

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.Эдийн засгийн үзүүлэлт							
A	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
1	Нүүрс олборлолт	м.тн	2,007.3	1,980.0	2,040.2	60.2	103.0
	Нүүрс борлуулалт	м.тн	1,988.6	2,126.0	2,049.8	(76.2)	96.4
	Нийт хөрс хуулалт	м.м	7,841.6	8,703.5	9,374.0	670.5	107.7
	Нийт уулын уул	м.м	13,333.0	13,906.2	14,405.6	499.4	103.6
2	Нийт орлого:	м.төг	57,892,474.6	65,449,908.0	59,588,400.9	(5,861,507.1)	91.0
	Үүнээс цэвэр борлуулалтын орлого	м.төг	57,710,409.3	65,233,268.1	59,347,899.6	(5,885,368.5)	91.0
3	Нийт зардал:	м.төг	60,196,778.3	70,395,013.7	68,212,041.4	(2,182,972.3)	96.9
	Удирдлагын зардал	м.төг	74,851.8	760,567.7	432,606.0	(327,961.7)	56.8
	Нийт өртөг	м.төг	60,196,778.3	70,395,013.8	68,212,041.4	(2,182,972.4)	96.9
4	Татвар төлөхийн өмнөх ашиг	м.төг	(2,304,303.8)	(4,945,105.6)	(8,623,640.6)	(3,678,535.0)	87.9
5	Төсвийн төлбөрт:	м.төг	9,557,964.4	10,654,974.0	9,783,891.7	(871,082.3)	96.8
	Үүнээс: а\ Орлогын татварт	м.төг	408.6	0.00	1,086.5	1,086.5	
	б\ НӨАТ	м.төг	5,771,040.9	6,523,326.8	5,934,790.0	(588,536.8)	91.0
	в\ Бусад татварт	м.төг	3,786,514.8	4,131,646.9	3,848,015.2	(283,631.7)	93.1
6	Нийт авлага	м.төг	2,843,249.5	2,910,234.5	5,971,849.2	3,061,614.7	205.2
7	Нийт өглөг	м.төг	127,956,604.9	121,124,757.5	133,926,323.8	12,801,566.3	110.6
	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	52,210,488.0	51,163,998.2	49,456,074.2	(1,707,924.0)	96.7
8	Сарын дундаж цалин	м.төг	1,278.3	1,899.0	1,378.7	(520.3)	72.6
9	1тн нүүрсний өртөг	төг	29,199.6	34,888.6	32,397.3	(2,491.3)	92.9
10	1тн нүүрсний дундаж үнэ	төг	29,021.1	30,683.7	28,953.1	(1,730.6)	94.3
11	1м ³ уулын цулын өртөг	төг	4,396.0	4,967.5	4,588.2	(379.3)	92.4
12	Нийт цалингийн сан	м.төг	12,798,472.7	13,262,942.0	12,988,697.9	(274,244.1)	97.9
13	Ажилчдын тоо	хүн	559	582	526	56	90.4

14	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.98	1.06	1.11	0.05	104.7
15	Хөдөлмөрийн бүтээмж, орлогоор	м.төг	103,238.7	124,429.5	113,191.6	(11,237.9)	91.0
16	Хөдөлмөрийн бүтээмж, ажлаар	м.м	23.9	26.4	27.4	1.0	103.7
II. Түлш эрчим хүчний найдвартай байдал							
1	Аваар, осол /техникийн/	тоо	0.0	0.0	0.0	0.0	
2	Хөрс хуулалтын коэффициент	М ³ /тн	3.9	4.4	4.6	0.2	104.5
3	Ус шүүрүүлэлт	М.куб	2,632.1	3,388.0	2,952.3	(435.7)	87.1
4	Нөхөн сэргээлтийн зардал	М.төг	49,580.0	125,000.0	16,400.0	(108,600.0)	13.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шүүхийн шийдвэрээр төлөгдөхгүй нь тодорхой болсон авлагыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх, авлага, өглөгийн бүртгэлийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 07-ны хооронд Ниямазон аудит ХХК-ийн аудитор Т.Оюун, А.Сүхбаатар, аудиторын туслах Ц.Оюунтунгалаг, М.Батцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ж.Батнасан, захирал З.Цээнээ нар хэрэгжүүлсэн.

Шивээ-Овоо ХК 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 3/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тухайлбал нэмэгдсэн өртгийн албан татварын хэрэгжээгүй авлага, хойшлогдсон татварын өглөгийн бүртгэл тодорхойгүй, санхүүгийн программ хангамжтай уялдаа сул байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 60,192.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 601.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын гүйцэтгэлийн үе шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Шивээ-Овоо ХК-ийн зорилго нь байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг үйлдвэр болоход оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Үүнд:

- Ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэл;
- Уул уурхайн үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн гадаад, дотоод худалдаа;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 90 хувийг төр буюу Эрдэнэс Монгол ХХК, 10 хувийг бусад хувьцаа эзэмшигчид тус тус эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 48 дугаар тогтоолоор Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчилж, 1995 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн анхдугаар хурлаар Шивээ-Овоо ХК-ийг үүсгэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь заалттай нийцэж байна.

Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 125.6 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Компанийн засаглал, ил тод байдлын хүрээнд ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгийг хараат бус гишүүдээс бүрдүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм журмын дагуу мэдээллийг цаг тухайд нь явуулж, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан компанийн санхүү болон үйл ажиллагааны мэдээллийг нийтэд олон нийтэд хүргэж байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж

ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу хэмнэлтийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, цалин хөлс, цахилгаан эрчим хүч, дулааны зардлаас 770.6 сая төгрөг хэмнэж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог өмнөх оноос 33-аар бууруулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Шивээ-Овоо ХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,881,311.2	409,413.8	(2,471,897.4)
Авлага	6,031,862.4	6,267,059.3	235,196.9
Найдваргүй авлагын хасагдуулга	(3,191,012.9)	(3,164,825.1)	(26,187.8)
Урьдчилгаа	5,880,137.8	2,869,615.1	(3,010,522.7)
Бараа материал	16,903,451.1	16,829,574.3	(73,876.8)
Үндсэн хөрөнгө	61,594,328.7	64,900,040.3	3,305,711.6
Биет бус хөрөнгө	189,628.4	189,628.4	0.0
Хөрс хуулалтын хөрөнгө	31,613,207.7	31,613,207.7	0.0
Хөрөнгө оруулалт	627,169.4	627,169.4	0.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	546,516.3	299,047.4	(247,468.9)
Нийт хөрөнгийн дүн	123,076,600.1	120,839,930.6	(2,236,669.5)
Өр төлбөрийн дүн	127,956,604.9	133,926,323.8	5,969,718.9
Богино хугацаат өглөг	52,212,179.8	49,455,505.2	(2,756,674.6)
Урт хугацаат өглөг	75,744,425.1	84,470,818.6	8,726,393.5
Эздийн өмч	(4,880,004.8)	(13,086,393.2)	(8,206,388.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	123,076,600.1	120,839,930.6	(2,236,669.5)

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 409.4 сая төгрөг болж буурсан байна. Үүнээс касс дахь бэлэн мөнгө 2.1 сая, 4 арилжааны банкны 7 харилцах дансанд 407.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй.
Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,471.9 сая төгрөгөөр буурсан нь өмнөх онд авсан зээлийн үлдэгдэл төлбөрт 3,600.0 сая төгрөг, МОНР4, МОНР5 төслийн зээлийн хүүнд 348.8 сая төгрөгийг эхний улиралд төлсөн.

- Авлага дансны үлдэгдэл 6,267.1 сая төгрөг болж 235.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нүүрсний борлуулалтын авлага 86.7 сая, хэрэгжээгүй НӨАТ-ын авлага 182.7 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Авлагын үлдэгдлийн 94.6 хувь буюу 5,485.5 сая төгрөг нь нүүрсний борлуулалтын авлага бөгөөд үүнээс 11 компанитай 1996 оноос үүссэн 1,615.9 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд хандсан байна. Нүүрсний 3,869.6 сая төгрөгийн авлага төлөгдөх хугацаандаа байгаа бөгөөд ДЦС-4 ТӨХК-иас авах 1,356.1 сая, Энержи плас ХХК-иас авах 589.7 сая төгрөгийн авлагатай.

Хүснэгт 2. Шүүхийн асуудалтай авлага

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Мөнгөн дүн	Дүнд эзлэх хувь
1.	Энэрэлт ээж ХХК	248,815.6	76.3
2.	Ханын материал ХК	44,087.3	13.5
3.	Квартит ХХК	17,196.9	5.3
4.	Сэлэнгэ гурванбулаг ХХК	10,000.0	3.1
5.	Гангар ХХК	5,878.8	1.8
	Нийт	325,978.6	100.0
1.	Сэлэнгэ энерго ОНААТҮГ	745,235.3	28.9
2.	Сэлэнгэ тэнгэр хараа ХХК	342,322.0	63.0
3.	Жаргалант алтай трейд ХХК	52,521.4	3.6
4.	Элбэг дулаан ХХК	43,000.0	4.5
	Нийт	1,183,078.7	100.0
1.	Ахлагч ЭШ ХХК	48,000.0	44.9
2.	Цагийн аяс ХХК	58,831.1	55.1
	нийт	106,831.1	100.0

Нэр бүхий 5 байгууллагатай 1996 оноос үүссэн 326.0 сая төгрөгийн авлага хариуцагч нь нас барсан, аж ахуйн нэгж нь татан буугдсан, нэхэмжлэгчээс тооцоогүй тухай бичиг ирүүлсэн зэрэг шалтгаанаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон байна. Мөн 2 компанитай холбоотой 106.8 сая төгрөгийн авлагын асуудлыг шийдвэрлүүлэхээр дээд шүүхэд хандсан, 4 байгууллагатай холбоотой 1,183.1 сая төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд явж байна.

- Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй бөгөөд завсрын аудитаар 2015 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас хийсэн залруулгаар хасагдсан 8 байгууллагын 26.2 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлагын нөөцөөс хассан байна.
- Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн 5,880.1 сая төгрөг, тайлант онд бараа, үйлчилгээний урьдчилгаанд 271.2 сая төгрөг төлж, ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 6,127.6 сая төгрөгийн ажил үйлчилгээ, бараа материалыг зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 16,829.6 сая төгрөг болж өмнөх оноос 73.9 сая төгрөгөөр буурсан нь хангамжийн материал 166.9 сая, тэсрэх материал 177.0 сая, сэлбэг хэрэгсэл 408.0 сая төгрөгөөр буурч, түлш шатах тослох материал 620.9 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Тайлант онд 67,998.4 сая төгрөгийн нүүрс олборлон орлогод авч, 29,753.4 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,305.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 13,748.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 522.0 сая төгрөгөөр капиталжуулж, нийт 14,270.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 10,783.3 сая төгрөгийн элэгдлийн зардлаар, 181.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийг акталснаар тус тус буурчээ.

Шивээ-Овоо ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 05 дугаар, ТУЗ-ийн 2021 оны 08 дугаар тогтоолоор ашиглалтын хугацаа дууссан, үйлдвэрлэлийн үр

өгөөж өгөхгүй болсон үндэслэлээр 872.9 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, 8,249.3 сая төгрөгийн 7 автосамосвал, 2 бульдозер, 2 гидро эксковатор зэрэг 14 технологийн автомашин, механизм, 694.7 сая төгрөгийн 12 цооног, нийт 9,816.9 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй хөрөнгийг акталсан байна.

- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 49,455.5 сая төгрөг болж 2,756.7 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: дансны өглөг 664.5 сая, татварын өр 1,614.6 сая, богино хугацаат зээл 1,820.0 сая, урьдчилж орсон орлого 4.8 сая төгрөгөөр буурч, цалингийн өглөг 554.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 118.7 сая, бусад богино хугацаат өр 674.3 сая төгрөгөөр өссөн байна.
- Урт хугацаат өр төлбөр дансанд 2021 онд санхүүгийн түрээсийн өглөгөөс 165.0 сая төгрөг, ажилчдын тэтгэврийн сангаас 221.3 сая төгрөгөөр буурсан хэдий ч шинэ техник худалдан авсантай холбоотойгоор нийт урт хугацаат өр төлбөрийн дүн 8,726.4 сая төгрөгөөр өссөн байна.
- Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор өгсөн зөвшөөрлийн дагуу Голомт банкнаас 2021 онд 5,000.0 сая төгрөгийн зээлийг борлуулалт багатай саруудад шатахуун, тэсрэх материал, татвар, нийгмийн даатгалын өр төлбөрийг төлөх зориулалттай авч, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт тухайн ондоо 3,620.0 сая төгрөг төлж, зээлийн үлдэгдэл 1,800.0 сая төгрөг байна.
- "Монгол нүүрс" төслийн хүрээнд Дэлхийн банк болон Япон улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон дамжуулан зээлдүүлэх гэрээний төлбөрийн 68,424.4 сая төгрөгийн өр урт хугацаат өглөгөөр тайлагнагдаж, нийт өр төлбөрийн 51 хувийг эзэлж байна. Энэхүү өрийг Шивээ-Овоо ХК-д оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох асуудлыг шийдэх тухай Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоол гарсан боловч хэрэгжээгүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад нийт 8,015.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түлш болон сэлбэгийн үнийн өсөлт, JBIC төслөөр авсан 5 технологийн автомашин, 2 гидро экскаваторын элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн Гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 17 дугаар тогтоолоор тус компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөг баталж, 2021 оны 6 дугаар сарын 14 дүгээр тогтоолоор тодотгон нийт орлогыг 4,850.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 65,449.9 сая, нийт зардлыг 5,225.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 70,395.0 сая, алдагдлыг 4,945.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Хүснэгт 3. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт					
	Нүүрс олборлолт	мян.тн	1,980.0	2,040.2	60.2	103.0
	Нүүрс борлуулалт	мян.тн	2,126.0	2,049.8	(76.2)	96.4
	Хөрс хуулалт	мян.мкуб	8,703.5	9,374.0	670.5	107.7
	Нийт уулын цул	мян.мкуб	13,906.0	14,405.6	499.4	103.6
2	Нийт орлого	сая.төг	65,449.9	59,588.4	(5,861.5)	91.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	сая.төг	65,233.3	59,347.9	(5,885.4)	91.0
3	Нийт зардал	сая.төг	70,395.0	68,212.0	(2,183.0)	96.9

	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	69,634.4	67,779.4	(1,855.0)	97.3
	Ерөнхий ба удирдлагын зардал	сая.төг	760.6	432.6	(328.0)	68.8
4	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	(4,945.1)	(8,623.6)	(3,678.5)	174.4

Тайлант онд 9,374.0 мянган метр куб хөрс хуулж, 2,040.2 мянган тонн нүүрс олборлон, 2,049.8 мянган тонн нүүрсийг 59,347.9 сая төгрөгөөр борлуулж, үйл ажиллагааны бус орлогоор 240.5 сая төгрөгийн орлого олж, нийт 59,588.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөг 9 хувиар тасалсан байна. Энэ нь сүүлийн хагас жилд 1 тонн нүүрсний үнийг 32,560.0 төгрөг болгохоор төлөвлөсөн ч нэмээгүйн улмаас 3,712.6 сая, борлуулалтын төлөвлөгөө 76.2 мянган тонн буюу 2,074.2 сая төгрөгөөр дутуу биелснээс голчлон шалтгаалжээ.

Нийт зардал гүйцэтгэлээр 68,212.0 сая төгрөг болж, батлагдсан төлөвлөгөөнөөс 2,183.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь 2,126.0 тонн нүүрс борлуулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 2,049.8 тонн борлуулсантай холбоотой байна.

Шивээ-Овоо ХК нь бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлээр 8,623.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь борлуулалтын орлогын төлөвлөгөө тасарсан, тээвэртэй хөрс хуулалт 479.3 мянган метр кубээр нэмэгдэж, JBIC төслийн хүрээнд авсан 5 технологийн машин, 2 гидро экскаваторын элэгдэл болон даатгалд 1,824.9 сая төгрөг, Эрдэнэс Монгол ХХК-д менежментийн төлбөрт 690.8 сая төгрөг, MONP4, MONP5 төслийн зээлийн хүүнд 917.1 сая төгрөг төлснөөс шалтгаалсан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2021 онд нийт 147,843.8 сая төгрөгийн 161 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 145.1 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.1-т *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шивээ-Овоо ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 06 дугаар сарын 14 дүгээр тогтоолоор тус компанийн 2021 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол хийж, нийт орлогыг 65,449.0 сая төгрөгөөр, алдагдлыг 4,495.1 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр орлогыг 5,861.5 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж, алдагдлыг 3,678.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 *"урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал*

нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, Шивээ-Овоо ХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.4.1 “компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна”, 13.4.9 “Монгол Улсын хууль тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид судалгаа, тооцоонд үндэслэн төсвийг бодитой төлөвлөх, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар баталсан Шивээ-Овоо ХК-ийн дүрмийн 1.2-т үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжийн жагсаалтад 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсон “Хүний хөгжлийн сангийн тухай хууль”-ийг оруулсан байна.

Автогрейдр болон конвейерийн сэлбэг худалдан авахаар 2 компанитай 173.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд сэлбэг хэрэгслээ хүлээн аваагүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2-т “компанийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанад биелүүлэх”, ШО/202101034 болон ШО/202001085 дугаар бүхий худалдах, худалдан авах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1-т “нийлүүлэгч нь захиалагчид нийлүүлэх сэлбэг, материалыг хуанлийн 14-21 хоногийн дотор нийлүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар дансны авлагаас хасагдсан 8 байгууллагын авлагыг найдваргүй авлагын нөөцөөс хасаагүй 26.2 сая, ангилал андуурч бүртгэсэн 5.3 сая, 2015 онд үүссэн хойшлогдсон татварын өглөгийг тайлант үеүдэд буцаан бичилт хийгээгүй 358.6 сая, нийт 390.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад залруулга хийсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 8,613.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 15.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж 88.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	7.6	2	7.6	-	-	100.0
Албан шаардлага	3	8,613.8	2	50.1	1	8,563.7	66.7
Зөвлөмж	3	15.2	3	15.2	-	-	100.0
Нийт дүн	8	8,636.6	7	72.9	1	8,563.7	88.9

Шилэн дансны цахим хуудсанд 8,563.7 сая төгрөгийн 55 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг арилгах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шивээ-Овоо ХК-ийн татварын хууль тогтоомжийн хэрэгжилт, НӨАТ-ын тооцоо дансны бичилт, үндсэн хөрөнгийн татварын зорилгоор элэгдүүлсэн тооцоолол, үндсэн хөрөнгийн капиталжуулалт, ашиглах хугацааг нэмэгдүүлсэн байдалд нарийвчилсан горим сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 347.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 347.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 347.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 601.9 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 254.4 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар олон жилийн насжилттай, хариуцагч нь нас барсан, аж ахуйн нэгж нь татан буугдсан, нэхэмжлэгчээс тооцоо дууссан тухай бичиг ирүүлсэн зэрэг шалтгаанаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон 325.9 сая төгрөгийн авлагын асуудлыг шийдвэрлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4 үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болсон авлагыг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, шийдвэрлүүлэх.

2. Өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жилийн эцсийн байдлаар Барловорлд Монголиа ХХК-д 791.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан ч тулган баталгаажуулалтаар тус компани нь 813.3 сая төгрөгийн авлагатай буюу өглөг 21.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Барловорлд Монголиа ХХК-тай үүссэн 21.5 сая төгрөгийн тооцооны зөрүүг байгуулсан гэрээ, холбогдох баримтын хүрээнд залруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Шивээ-Овоо ХК	АХГ-2022/59/НА-СТА-ТӨА	Олон жилийн насжилттай, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болсон авлагыг шийдвэрлээгүй	Авлагын асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан, шийдвэрлүүлэх	1	325,978.6									1	325,978.6
2	Шивээ-Овоо ХК	АХГ-2022/59/НА-СТА-ТӨА	Авлага, өглөгийн тулган баталгаажуулалтаар зөрүү үүссэн	Барловорлд Монголиа ХХК-тай үүссэн 21.5 сая төгрөгийн тооцооны зөрүүг байгуулсан гэрээ, холбогдох баримтын хүрээнд залруулах	1	21,498.9									1	21,498.9
ДҮН					2	347,477.5					1				2	347,477.5
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Шивээ-Овоо ХК	АХГ-2022/59/НА-СТА-ТӨА	Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон	Шилэн дансанд мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлэх	1	145,071.4							1	145,071.4		
2	Шивээ-Овоо ХК	АХГ-2022/59/НА-СТА-ТӨА	Сэлбэг худалдан авах 2 гэрээ хугацаандаа хэрэгжээгүй	Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах албан шаардлага өгөх	1	173,934.9					1	173,934.9				
3	Шивээ-Овоо ХК	АХГ-2022/59/НА-СТА-ТӨА	Төлөвлөсөн алдагдлыг хэтрүүлсэн	Алдагдлыг бууруулахад анхаарч ажиллах албан шаардлага өгөх	1						1					
ДҮН					3	319,006.3					2	173,934.9	1	145,071.4		
НИЙТ ДҮН					5	666,483.8					2	173,934.9	1	145,071.4	2	347,477.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 604/А0150053
АХС- 2022/59/НА.СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 145,071,449.00 төгрөгийн ажил, гүйлгээний 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулан зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргасан цахим мэдээллийн инженер С.Дэлгэрэхэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шивээ-Овоо ХК-ийн захирал Ц.Энхтүвшинд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ


АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

В.ЦЭЭНЭЭ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 602/АУ150053

Улаанбаатар хот

АХГ - 2022/59/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автогрейдр болон конвейерийн сэлбэг худалдан авахаар 2 компанитай 173,934,860.00 төгрөгийн гэрээ байгуулсан ч гэрээний хугацаанд сэлбэг хэрэгслийг хүлээн аваагүй, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулаагүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4.2 "компанийн эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанад биелүүлэх", ШО/202101034 болон ШО/202001085 дугаар бүхий худалдах, худалдан авах гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 "нийлүүлэгч нь захиалагчид нийлүүлэх сэлбэг, материалыг хуанлийн 14-21 хоногийн дотор нийлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Автогрейдр болон конвейерийн сэлбэг худалдан авах 173,934,860.00 төгрөгийн 2 гэрээний биелэлтийг хангуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ-Овоо ХК-ийн захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

ГЭРЭЭГЭЭВ ГҮЙЦЭТГЭГЧ:

НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

З.ЦЭЭНЭЭ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-284.Docx

0001021574



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 605/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/59/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны нийт орлогыг 65,449,900,000.00 төгрөгөөр, нийт зардлыг 70,395,000,000.00 төгрөгөөр, 4,945,100,000.00 төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 59,588,400,789.32 төгрөгийн орлого бүрдүүлж, 68,212,041,405.62 төгрөгийн зардал гарган, 8,623,640,616.30 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, Шивээ-Овоо ХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.4.1 “компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна”, 13.4.9 “Монгол Улсын хууль тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид судалгаа, тооцоонд үндэслэн төсвийг бодитой төлөвлөх, зорилтот түвшний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шивээ-Овоо ХК-ийн захирал Ц.Энхтүвшин, ерөнхий нягтлан бодогч Н.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ЭНХДАЛАЙ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  З.ЦЭЭНЭЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, “1-р саяа”, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-297.Docx

0001081607

